



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/351

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 15, 2025 оны 37 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.5.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Итали Улсын Montesilvano хотод болох өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Батпэлдэн овогтой Буянхишигийн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ